

2025 ОН IV УЛИРЛЫН ТАЙЛАН

MSE:MLG

www.mlholding.mn





КОМПАНИЙН ТУХАЙ

2005 онд Монгол Улсад тээвэр зуучийн үйлчилгээний нэгэн шинэ хуудсыг эхлүүлж, цөөн хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж байсан Монложистикс Групп 2025 онд 20 нас хүрлээ. Анх арваадхан хүнтэй үйл ажиллагаа эхлүүлж байсан Монложистикс Групп нь өнөөдөр 1 толгой компани, 7 охин компани, 210 гаруй ажилтан, дэлхийн 163 орны 800 гаруй харилцагч түнш, дотоодын 1500 гаруй үйлчлүүлэгчтэй Монгол Улсын тээвэр ложистикийн салбарын тэргүүлэгч групп болон өргөжин тэлжээ. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд бид Монгол Улсын эдийн засгийн чухал салбар болох тээвэр ложистикийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, иргэдийн өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлохоос эхлэн уурхайн түүхийг эдийг экспортлох, хөрш болон гуравдагч орнуудыг ачаа тээврээр холбох хүртэл импорт, экспорт, транзит, тракинг, карго зэрэг тээвэр ложистикийн бүх төрлийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн үзүүлсээр ирлээ. 20 жилийн турш бид харилцагч, ажилтнууд, түншүүдийнхээ итгэл дээр тулгуурлан, инновац, чанар, хариуцлагыг эрхэмлэж ажилласан бөгөөд энэ хугацаанд бизнесийн тогтвортой өсөлт, менежментийн шилдэг туршлага, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай групп компанийг бий болгожээ. Монложистикс Холдинг ХК нь группийн охин компаниудын бодлого, стратеги, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрт хүний нөөц, санхүү, мэдээллийн технологи, маркетинг, стратеги ба бизнес хөгжил, ложистик гэсэн 6 чиглэлд менежментийн үйлчилгээ үзүүлдэг толгой компани юм.



ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

IV УЛИРЛЫН ТАЙЛАН 2025

ЭРХЭМ ЗОРИЛГО

ДЭЛХИЙ РҮҮ ТЭМҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ БРЭНД

АЛСЫН ХАРАА

Бид 2030 онд орчин үеийн дэд бүтэц, үйлчилгээний чанар дээр суурилсан цогц ложистик үйлчилгээг нэвтрүүлж, улмаар Монгол Улсыг Ази Европыг холбосон ложистик төв болгоно.



ҮНЭТ ЗҮЙЛС



Өндөр чадвартай, мэргэжлийн хамт олон

Ажилтан бүр өөрийгөө олж нээн, авьяас чадвараа суралцах их хүсэл эрмэлзлээр хөгжүүлэн, оюун ухаан, хүч хөдөлмөрөө харамгүй зориулснаар өөртөө болон байгууллагад амжилт бүтээл дагуулж, бусдадаа үлгэрлэн манлайлах замаар дараагийн залгамж манлайлагч нарыг тасралтгүй төрүүлдэг байна.



Инновацлаг багийн сэтгэлгээ

Манай хамт олон инновац, бүтээлч сэтгэлгээгээрээ багийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан төгөлдөршүүлэхийн төлөө цаг үетэй хөл нийлүүлж, техник технологийн хөгжлийг хурдтай нэвтрүүлж, байнга шинийг санаачлагч багуудаас бүрдэнэ.



Хариуцлага, сахилга бат

Манай байгууллагын ажилтан бүр өөрийн хариуцсан ажлыг хийхдээ хувийн өндөр сахилга баттай байж, ажилдаа өөриймсөг сэтгэлээр хандаж, Монгол Улсын хууль тогтоомж, Группийн дотоод үйл ажиллагааны стандартыг ёс зүйтэй мөрдөж, ямар ч ажлыг туйлын хариуцлагатайгаар, чанар стандартын дагуу гүйцэтгэдэг байна.



Бусдыг хүчирхэгжүүлэх манлайллын соёл

Манай ажилтан бүр тасралтгүй суралцан, мэдлэг оюунаа тэлж, мэргэжлийн болон ерөнхий ур чадвараар цаг үетэйгээ үргэлж нийцэж, дэлхийн өнцөг булан бүрийн аль ч компанид тэнцэн ажиллах чадамж бүхий зорилго нэгт баг хамт олны нэг хэсэг байна.



Шударга, ил тод байдал

Манай бүх үйл ажиллагаа том жижиг, их багаас үл хамааран үнэнч шударга байх зарчим дээр суурилан бүхий л оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг нээлттэй ойлгомжтой, үнэн зөвөөр цаг ямагт хүргэж байх болно.

ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Монголын Тээвэр зуучийн
нэгдсэн холбоонд албан
ёсны гишүүнээр элсэв.

2006 ОН

Монгол Улсын Гаалийн
ерөнхий газраас Гаалийн
зуучлагчийн тусгай
зөвшөөрлийг авав.

2010 ОН

Олон улсын тээвэр
зуучийн нэгдсэн
холбоонд албан ёсны
гишүүнээр элсэв.

2014 ОН

Rebranding
“Upgrade 10” төслийг
амжилттай эхлүүлэв.

2016 ОН

2005 ОН

Монложистикс Ворлдвайд ХХК
анхны ууган компани
байгуулагдав.



2009 ОН

Төмөр замын аюулгүй
ажиллагааны тусгай
зөвшөөрлийг хүлээн авав.



2011 ОН

Монголын гаалийн
зуучлагчдын
нэгдсэн холбооны
гишүүнээр элсэв.



2015 ОН

ISO 9001:2008 Олон улсын
чанарын удирдлагын
тогтолцоог нэвтрүүлэв.





Оюу толгой компанийн албан ёсны тээврийн компаниар шалгарав.



Монложистикс Холдинг ХХК
Толгой компани байгуулагдав.



Түүхий эдийн экспортын тээврийг эхлүүлж, Кaus Аустралис ХХК-ийг байгуулав.



CORE системийн шинэчлэл хийгдэв. Группт 3 шинэ охин компани нэмэгдэв.

2018 ОН

2020 ОН

2022 ОН

2024 ОН



2017 ОН

2019 ОН

2021 ОН

2023 ОН

2025 ОН

Бүх тээврийг даатгалд хамруулах үйлчилгээг нэвтрүүлэв.

Монложистикс Транзит ХХК байгуулагдав.

Портфолио өргөжилт хийж, 3 охин компаниа байгуулав.

Монложистикс Холдинг ХХК Олон нийтэд нээлттэй компани болов.

Монложистикс Холдинг ХК Do good HUB ТББ-ыг байгуулав.

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны 20 жилийн ой



ГРУППИЙН БҮТЭЦ



Монложистикс Экспресс ХХК, Монложистикс Тракинг ХХК-иуд нь 2026 оноос Монложистикс Ворлдвайд ХХК-тай бүтэц, үйл ажиллагаагаа нэгтгэсэн.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



МОНЛОЖИСТИКС ГРУПП ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙ

Монложистикс групп үүсгэн байгуулагдсаны хорин жилийн ой 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр тохиолоо. Өнгөрсөн хорин жилийн хугацаанд бизнесийн үр ашгаас илүүтэй салбартаа шинэ соёл, ложистикийн шинэ шийдэл, менежментийн стандарт, хариуцлагын жишиг тогтоосноороо бид манлайлагчийн байр сууринд хүрч, олон нийтийн оролцоотой нээлттэй компани болжээ.

Компани үүсгэн байгуулагдсан цагаас хойш тасралтгүй хорин жилийн хугацаанд идэвх зүтгэлтэй ажиллаж, компанидаа болон салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан ажилтнуудын хөдөлмөр зүтгэлийг нь өндрөөр үнэлж, төрийн дээд одон медалиар шагнагдсан бол компанийн зүгээс тогтвор суурьшилтай ажиллаж буй 28 ажилтнуудыг гадаад улсад аялах эрхээр, нийт ажилтнуудыг мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан юм.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Монголын Хөрөнгө Оруулалтын Форумд оролцлоо.

Сингапур улсад 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан Монголын хөрөнгө оруулалтын форумын гол төлөөлөгчид нь Goldman Sachs, J.P. Morgan, Morgan Stanley, Deutsche Bank, BlackRock болон олон улсын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө удирдагчид зэрэг 100+ оролцогчтой томоохон арга хэмжээ болсон юм.

Монложистикс Холдинг ХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Хишигбат тус форумд оролцож, компанийн болон салбарын үйл ажиллагааг оролцогчдод танилцуулж, илтгэл тавьсан.



ISO 9001:2015 стандартын магадлан аудитад амжилттай тэнцлээ.

Бид группийн хэмжээнд олон улсын чанарын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн билээ. Австралийн TQCSI олон улсын стандартын баталгаажуулалтын байгууллагаас ISO 9001:2015 стандартын хэрэгжүүлэлтийг магадлан баталгаажууллаа.

Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлснээр бид байгууллагынхаа бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгч, харилцагчдадаа найдвартай, тогтвортой бөгөөд чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, урт хугацаанд хамтран ажиллах эрхэм зорилгоо улам баталгаажуулах юм.



Хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөр үргэлжилж байна.

Монложистикс Холдинг ХК (MSE:MLG) нь 4,8 сая ширхэг хувьцаагаа нэгж бүрийг нь 210 төгрөгөөр үнэлж нээлттэй зах зээл дээрээс эргүүлэн худалдаж авахаа зарласан билээ. Хувьцаагаа халаасалсны үр дүнд хувьцааны эрэлт нэмэгдэж, арилжааны идэвхжил сайжрах, хувьцааны үнэ тогтвортой байх, өсөх, хөрөнгө оруулалтын сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 782,178,689.7 (долоон зуун наян хоёр сая нэг зуун далан найман мянга зургаан зуун наян есөн) төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааг нээлттэй зах зээлээс хувьцааны хөрвөн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор эргүүлэн худалдаж аваад байна. Энэхүү хөтөлбөрийг анх зарласан 1,008,000,000 төгрөгийн хувьцааг эргүүлэх худалдаж авахаар үргэлжлэх хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар шийдвэрлэсэн.

НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛЭЭС
ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ
ХУГАЦААГ СУНГАЛАА

Эргүүлэн худалдаж авах
хувьцааны нийт тоо, ширхэг

4,800,000
ШИРХГЭЭС ИХГҮЙ

Эргүүлэн худалдан авах
захиалгын дээд үнэ

210₮

Эргүүлэн худалдан авах
хувьцааны нийт дүн

1,008,000,000₮

Эргүүлэн худалдан
авах хугацаа

**2025.04.01
2026.03.31**

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК

**НОГДОЛ АШИГ
ТАРААНА**

цэвэр ашгийн

23.9%

НИЙТ

2,295,981,167.60₮


нэгж хувьцаанд

5.80₮

ногдол ашиг
тараах өдөр

2026.04.30

ОНЦЛОХ ТЭЭВЭР



Уран зургийн тээвэрлэлт

БНХАУ-ын Бээжин хотод 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2026 оны 02 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл зохион байгуулагдсан "Бээжингийн олон улсын дүрслэх урлагийн биенналь 2025" арга хэмжээнд Монгол Улсыг төлөөлөн 5 уран бүтээлч өөрийн бүтээлээрээ оролцсон юм. Уг үзэсгэлэнд нийт 189 кг жинтэй, 104,088.00 ам.долларын үнэлгээ бүхий бүтээлүүдийн тээвэрлэлтийг амжилттай зохион байгуулаа.



Тоног төхөөрөмжийн тээвэрлэлт

2025 оны 10 дугаар сард БНХАУ-ын Эрээн хотоос Эрдэнэт хот руу нийт 76 тонн жинтэй тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг мэргэжлийн хяналт, тээврийн стандартын дагуу зохион байгуулж, төлөвлөсөн хугацаанд хийж гүйцэтгэлээ.



Бульдозер болон бойлерын тээвэрлэлт

Ганц Мод боомтоос Гашуун Сухайт боомтын чиглэлд хүнд оврын тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг амжилттай зохион байгууллаа. Нийт 5 ширхэг гинжит бульдозер, 1 ширхэг Zosen брэндийн үйлдвэрийн бойлерыг тус тус хүнд даацын тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл, мөн бэхэлгээ, хамгаалалтын стандарт шаардлагыг бүрэн хангаж амжилттай тээвэрлэлээ.




Үйл ажиллагааны тайлан

- › Тээврийн салбарын нийт орлого
- › Монложистикс Группийн орлого
- › Тээврийн салбарын ачааны нийт хэмжээ
- › Монложистикс Группийн ачааны хэмжээ

ТЭЭВРИЙН САЛБАРЫН ОРЛОГО

/ ИХ НАЯД ТӨГРӨГӨӨР /




2025 оны 4-р улирлын байдлаар тээврийн салбарын орлого 8.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 10.7% буурсан байна.

"Эх сурвалж: ҮСХ, ГЕГ, ЗТЯ-ны мэдээлэл дээр үндэслэн бэлтгэсэн дотоод судалгаа болно."


МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН ОРЛОГО

/ ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР /




2025 оны 4-р улирлын байдлаар Монложистикс Группийн орлого 290 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 2.2% буурсан байна.

ТЭЭВРИЙН САЛБАРЫН НИЙТ АЧААНЫ ХЭМЖЭЭ / СЯ ТОННООР /



2025 оны 4-р улирлын байдлаар Монгол Улсын нийт ачаа тээврийн эргэлтийн хэмжээ 146 сая.тн хэмжээнд хүрч өмнөх мөн үетэй харьцуулахад 9.3% өссөн байна.



МОНЛОЖИСТИКС ГРУППИЙН АЧААНЫ ХЭМЖЭЭ / МЯНГАН ТОННООР /





Монложистикс группийн ачаа эргэлт 808 мян.тн хүрч өмнөх оны мөн үеэс 29% буурсан үзүүлэлттэй байна.





ЭКСПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ




ИМПОРТЫН АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ



ТРАНЗИТ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ



ОЛОН УЛС ДАХ АЧАА ТЭЭВРИЙН ХЭМЖЭЭ





САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2023 Q4	2024 Q4	2025 Q4
Борлуулалтын орлого	210,361	296,858	289,919
Борлуулалтын өртөг	(192,253)	(272,477)	(263,766)
Нийт ашиг	18,108	24,381	26,153
Борлуулалт, Удирдлагын зардал	(8,482)	(11,191)	(13,232)
Бусад орлого (зардал)	(324)	(496)	1,962
Үйл ажиллагааны цэвэр ашиг	9,302	12,695	14,883
Санхүүгийн орлого (зардал)	283	(749)	(2,831)
Татварын өмнөх цэвэр ашиг (EBT)	9,585	11,946	12,053
ОАТ-н зардал	(1,222)	(1,600)	(1,824)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			(624)
Цэвэр ашиг	8,363	10,346	9,605
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,925	7,339	6,914
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,438	3,008	2,691
Бүх дэлгэрэнгүй орлого			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	(62)	(106)	(311)
Бусад олз (гарз)		(212)	
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	8,301	10,028	9,915
Толгой компанийн хувьцаа эзэмшигчид	5,863	7,020	7,193
Хяналтын эрхгүй хувь оролцоо	2,438	3,008	2,722
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг (алдагдал)	14.97	18.54	17.47

НЭГТГЭСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлангын үзүүлэлт (сая ₮)	2023 Q4	2024 Q4	2025 Q4
Мөнгөн хөрөнгө	22,122	8,709	12,288
Дансны авлага	22,535	40,036	46,019
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2,461	1,811	-
Бараа материал	135	8,025	4,503
Урьдчилж төлсөн төлбөр	6,050	21,257	10,618
Бусад эргэлтийн хөрөнгө	1,274	2,242	1,886
Эргэлтийн хөрөнгө	54,577	82,080	75,313
Үндсэн хөрөнгө	1,526	5,466	14,472
Ашиглах эрх бүхий хөрөнгө	952	559	508
Бусад эргэлтийн бус хөрөнгө	553	787	675
Гудвилл	-	3,463	3,518
Эргэлтийн бус хөрөнгө	3,031	10,275	19,172
Нийт хөрөнгө	57,609	92,355	94,485
Дансны өглөг	12,409	22,059	20,082
Урьдчилж орсон орлого	837	8,004	4,149
Богино хугацаат зээл	17	6,733	9,797
Бусад өглөг	465	457	281
Богино хугацаат өр төлбөр	13,728	37,253	34,309
Урт хугацаат өр төлбөр	442	6,452	4,801
Нийт өр төлбөр	14,169	43,705	39,110
Эздийн өмч	39,285	42,325	47,264
Хяналтын эрхгүй хувь оролцоонд ногдох	4,154	6,325	8,111
Нийт Эздийн өмч	43,439	48,650	55,375
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	57,609	92,355	94,485

*Аудитлагдаагүй тайлан



ХАЯГ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Нью хоризонс оффис, 11 давхар, 1101 тоот

ХОЛБОО БАРИХ

+976 7701-5454
info@monlogistics.mn
www.mlholding.mn